

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны ⁰⁹ дугаар
сарын ²⁸ өдөр

Дугаар ^{А/448, А/225, А/177} Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23 дахь хэсэг, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайд, Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2020 оны А/145, А/57, А/37 дугаар “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан Цэргийн төв эмнэлгийн үзүүлж буй тусламж, үйлчилгээг шилжүүлэх хуваарийн “Багахангай, Баянзүрх дүүргийн иргэдийн яаралтай мэс заслын тусламж, үйлчилгээг Улсын нэгдүгээр төв эмнэлэг” гэснийг “Багахангай, Баянзүрх дүүргийн иргэдийн яаралтай мэс заслын тусламж, үйлчилгээг Улсын хоёрдугаар төв эмнэлэг” гэж өөрчилсүгэй.
2. Тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд хуваарийн шинэчлэлийг иргэдэд чирэгдэл үүсгэхгүйгээр зохицуулахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирал (Н.Лхажий), Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал (С.Энхболд) нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд Ш.Анхмаа, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд С.Баатаржав нарт даалгасугай.

